

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/517/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер	Х.Түвшинбаяр
	Утас: 327734	Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер:	С.Гантөгс
	Утас: 315558	Цахим хаяг: gantugss@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Н.Бадамхатан
	Утас: 325093	Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn
	Аудитор: Ц.Цэнд-Аюуш	Цахим хаяг: tsend-ayushts@audit.gov.mn
	Утас: 325093	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-02-25 № 208

танай _____-ны № _____-т

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ПРОКУРОРЫН ГАЗРЫН ТАМГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА
С.ЭНХМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газарт Улсын ерөнхий прокурорын газраас цахим хурлын төхөөрөмжөөр хангаснаар цахим шүүх хурлын өрөөтэй болж, прокурорууд цаг хугацаа, орон зай харгалзахгүйгээр шүүх хуралд цахимаар оролцох нөхцөл бүрдсэн нь ажлын бүтээмжид сайнаар нөлөөлсөн байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газрын тайлант оны төсөв өмнөх оны төсвийн гүйцэтгэлээс 18.9 хувиар нэмэгдсэн нь УИХ-ын 2025 оны 24 дүгээр тогтоолоор прокуроруудын, ЗГ-ын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан

хаагчдын цалингийн хэмжээг тус тус шинэчлэн тогтоож, нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Нийт төсвийн 86.4 хувийг цалин хөлстэй холбоотой зардал эзэлж байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудал

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт дэвшүүлэн, 49 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, бүрэн хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР




Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>231,420,389.85</u>	<u>167,947,044.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	110,936,150.00	85,636,150.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	110,936,150.00	85,636,150.00
3121	Төгрөг	110,936,150.00	85,636,150.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	110,936,150.00	85,636,150.00
34	УРЬДЧИЛГАА	15,996,000.00	8,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	15,996,000.00	8,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	103,524,932.00	74,110,894.00
354	Хангамжийн материал	103,524,932.00	74,110,894.00
35410	Бичиг хэргийн материал	5,938,170.00	2,033,500.00
35420	Аж ахуйн материал	12,506,840.00	5,500.00
35440	Түлш, шатах тослох материал	1,850,000.00	700,000.00
35470	Бусад хангамжийн материал	83,229,922.00	71,371,894.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>845,094,286.53</u>	<u>831,191,427.90</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	845,094,286.53	831,191,427.90
392	Биет хөрөнгө	824,199,036.53	810,296,177.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	547,821,199.00	547,821,199.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-53,601,226.08	-64,551,172.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	157,080,000.00	136,420,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-22,879,166.74	-14,873,333.29
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	284,448,082.63	293,280,536.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	-160,378,040.48	-137,339,303.63
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	118,937,521.15	96,573,962.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	-47,229,332.95	-47,035,709.96
393	Биет бус хөрөнгө	20,895,250.00	20,895,250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,895,250.00	20,895,250.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,076,514,676.38</u>	<u>999,138,471.90</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>110,936,150.00</u>	<u>85,636,150.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	110,936,150.00	85,636,150.00
412	Богино хугацаат зээлийн өглөг	110,936,150.00	85,636,150.00
4121	Төгрөг	110,936,150.00	85,636,150.00
41213	Барьцаа дэнчингийн урьдчилж орсон орлого	110,936,150.00	85,636,150.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>965,578,526.38</u>	<u>913,502,321.90</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	965,578,526.38	913,502,321.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	185,094,859.53	185,094,859.53

51101	Өмч: - төрийн	185,094,859.53	185,094,859.53
512	Хуримтлагдсан үр дүн	443,353,646.85	391,277,442.37
51210	Өмнөх үеийн үр дүн	443,353,646.85	443,353,646.85
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-52,076,204.48
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	337,130,020.00	337,130,020.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,076,514,676.38</u>	<u>999,138,471.90</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,853,154,961.59	5,557,258,844.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	193,468,261.59	80,266,044.48
120	Нийтлэг татварын бус орлого	193,468,261.59	80,266,044.48
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,659,686,700.00	5,476,992,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,575,186,700.00	5,438,492,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,575,186,700.00	5,438,492,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	84,500,000.00	38,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,500,000.00	38,500,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,727,941,023.46	5,605,020,887.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,727,941,023.46	5,605,020,887.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,545,644,324.81	5,479,151,169.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,719,401,955.11	4,588,764,633.87
210101	Үндсэн цалин	2,131,957,535.71	2,589,594,133.75
210102	Нэмэгдэл	1,000,251,756.40	1,554,559,456.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	255,838,000.00	267,471,667.73
210104	Урамшуулал	331,354,663.00	177,139,376.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	465,388,161.37	575,608,249.27
210201	Тэтгэврийн даатгал	318,557,130.13	394,247,030.75
210202	Тэтгэмжийн даатгал	37,448,191.74	46,382,002.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,651,496.40	23,000,261.72
210204	Ажилгүйдлийн даатгал	18,146,269.07	22,395,790.33
210205	Эрүүл мэндийн даатгал	72,585,074.03	89,583,163.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,594,791.02	29,870,542.95
210301	Гэрэл, цахилгаан	10,383,352.92	14,300,422.89
210302	Түлш, халаалт	16,885,611.90	13,882,981.91
210303	Цэвэр, бохир ус	3,325,826.20	1,687,138.15

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

2104	Хангамж, бараа материалын зардал	80,168,242.55	86,154,225.20
210401	Бичиг хэрэг	53,191,480.00	33,622,590.00
210402	Тээвэр, шатахуун	7,350,000.00	7,320,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,533,072.55	5,097,377.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	775,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,318,690.00	14,306,890.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	25,506,718.00
2105	Норматив зардал	3,948,100.00	2,322,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,948,100.00	2,322,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,622,806.45	4,957,100.00
210604	Урсгал засвар	15,622,806.45	4,957,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	102,237,317.00	15,272,677.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,987,066.00	13,463,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	62,600.00	1,621,526.00
210807	Газрын төлбөр	187,651.00	187,651.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	128,282,951.31	176,201,741.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,163,000.00	72,139,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	88,869,951.31	104,062,741.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	182,296,698.65	125,869,717.56
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	176,006,698.65	125,869,717.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	176,006,698.65	125,869,717.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	125,213,938.13	(47,762,042.94)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,416.85	4,314,161.54
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	4,314,161.54
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(6,416.85)	(4,314,161.54)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	125,207,521.28	(52,076,204.48)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,750,125,950.00	5,476,992,800.00
120009	Бусад орлого	90,439,250.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,659,686,700.00	5,476,992,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,575,186,700.00	5,438,492,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,575,186,700.00	5,438,492,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	84,500,000.00	38,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,500,000.00	38,500,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,659,686,600.00	5,488,084,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,659,686,600.00	5,488,084,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,477,389,901.35	5,336,915,082.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,720,365,262.96	4,587,801,326.02
210101	Үндсэн цалин	2,136,796,412.38	2,588,630,825.90
210102	Нэмэгдэл	999,616,189.89	1,554,559,456.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	258,536,251.91	267,471,667.73
210104	Урамшуулал	325,416,408.78	177,139,376.22
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	465,388,161.37	575,608,249.27
210201	Тэтгэврийн даатгал	318,477,930.13	394,247,030.75
210202	Тэтгэмжийн даатгал	37,467,991.74	46,382,002.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,667,336.40	23,000,261.72
210204	Ажилгүйдлийн даатгал	18,150,229.07	22,395,790.33
210205	Эрүүл мэндийн даатгал	72,624,674.03	89,583,163.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,594,791.02	29,870,542.95
210301	Гэрэл, цахилгаан	10,383,352.92	14,300,422.89
210302	Түлш, халаалт	16,885,611.90	13,882,981.91
210303	Цэвэр, бохир ус	3,325,826.20	1,687,138.15
2104	Хангамж, бараа материалын зардал	71,288,612.55	56,241,387.20
210401	Бичиг хэрэг	44,776,920.00	32,331,070.00
210402	Тээвэр, шатахуун	8,410,000.00	6,170,650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,263,072.55	5,097,377.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	775,000.00	300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,063,620.00	12,342,290.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,250,000.00	5,001,900.00
210604	Урсгал засвар	9,250,000.00	5,001,900.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	126,494,073.45	15,272,677.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	126,243,922.45	13,463,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	62,500.00	1,621,526.00
210807	Газрын төлбөр	187,651.00	187,651.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,009,000.00	64,797,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,759,000.00	64,797,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	250,000.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	182,296,698.65	151,169,717.56
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		25,300,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		25,300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,290,000.00	0,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,290,000.00	0,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	176,006,698.65	125,869,717.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	176,006,698.65	125,869,717.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	90,439,350.00	(11,092,000.00)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0,00	0,00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0,00	14,208,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	14,208,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	14,208,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	14,208,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0,00	(14,208,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	90,439,350.00	(25,300,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,496,900.00	110,936,150.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	110,936,150.00	85,636,150.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	185,094,859.53	337,130,020.00	318,146,125.57	840,371,005.10
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	185,094,859.53	337,130,020.00	318,146,125.57	840,371,005.10
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	125,207,521.28	125,207,521.28
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	185,094,859.53	337,130,020.00	443,353,646.85	965,578,526.38
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	185,094,859.53	337,130,020.00	443,353,646.85	965,578,526.38
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	185,094,859.53	337,130,020.00	443,353,646.85	965,578,526.38
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-52,076,204.48	(52,076,204.48)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	185,094,859.53	337,130,020.00	391,277,442.37	913,502,321.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Эдийн засгийн Анги Ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,438,492,800.00	5,312,624,782.44	98%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,438,492,800.00	5,312,624,782.44	98%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,438,492,800.00	5,312,624,782.44	98%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,681,821,800.00	4,587,801,326.02	98%
210101	Үндсэн цалин	2,233,997,300.00	2,588,630,825.90	116%
210102	Нэмэгдэл	1,847,323,500.00	1,554,559,456.17	84%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	288,485,700.00	267,471,667.73	93%
210104	Урамшуулал	312,015,300.00	177,139,376.22	57%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	600,389,700.00	575,608,249.27	96%
210201	Тэтгэврийн даатгал	408,360,000.00	394,247,030.75	97%
210202	Тэтгэмжийн даатгал	48,042,300.00	46,382,002.93	97%
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,015,800.00	23,000,261.72	96%
210204	Ажилгүйдлийн даатгал	23,994,400.00	22,395,790.33	93%
210205	Эрүүл мэндийн даатгал	95,977,200.00	89,583,163.54	93%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,370,800.00	29,870,542.95	92%
210301	Гэрэл, цахилгаан	14,540,400.00	14,300,422.89	98%
210302	Түлш, халаалт	13,648,000.00	13,882,981.91	102%
210303	Цэвэр, бохир ус	4,182,400.00	1,687,138.15	40%
2104	Хангамж, бараа материалын зардал	60,169,300.00	56,241,387.20	93%
210401	Бичиг хэрэг	28,978,100.00	32,331,070.00	112%
210402	Тээвэр, шатахуун	7,120,700.00	6,170,650.00	87%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,532,700.00	5,097,377.20	48%
210404	Ном, хэвлэл	1,195,000.00	300,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,342,800.00	12,342,290.00	100%
2105	Норматив зардал	2,322,000.00	2,322,000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,322,000.00	2,322,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,006,900.00	5,001,900.00	100%
210604	Урсгал засвар	5,006,900.00	5,001,900.00	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,426,300.00	15,274,377.00	99%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,465,200.00	13,465,200.00	100%

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,773,400.00	1,621,526.00	
210803	Даатгалын үйлчилгээ	187,700.00	187,651.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,986,000.00	40,505,000.00	99%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,986,000.00	40,505,000.00	99%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,447,678,800.00	5,312,624,782.44	98%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,447,678,800.00	5,312,624,782.44	98%
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,447,678,800.00	5,312,624,782.44	98%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	110,936,150.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	85,636,150.00	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	73	66	90%
620001	Удирдах ажилтан	1	1	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	59	52	88%
620003	Үйлчлэх ажилтан	13	13	100%

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	38,500,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,500,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,500,000.00

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Мөнгөн хөрөнгийг түүвэрлэж үзэхэд анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн байна.	1	1669.0					1	1669.0				
Ажиллагсадтай холбоотой авлагын журналын бичилтийг 29.7 мянган төгрөгөөр буруу хийсэн байна.	1	29.7					1	29.7				
Дүн	2	1698.7					2	1698.7				

